

“Эбола” вирус болон бусад шинээр бүртгэгдэж байгаа халдварын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл “Эбола” вирус болон бусад шинээр бүртгэгдэж байгаа халдварын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зарим арга хэмжээний тухай ҮАБЗ-ийн Нарийн бичгийн дарга Ц.Энхтүвшингийн танилцуулгыг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ БОЛГОХ нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газарт:

1. Дэлхий даяар тархаж байгаа “Эбола” вирус болон бусад шинээр бүртгэгдэж байгаа халдварын хяналтын тогтолцоог болон биотерроризмын аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хууль эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээ авах;

2. Шинээр бүртгэгдэж байгаа халдварыг тандах, тархан дэлгэрэх аюулыг таслан зогсоох, сөрөг арга хэмжээ авч ажиллахад бүх холбогдох байгууллагын бэлэн байдлыг хангахад шаардагдах мэдээлэл, арга зүйгээр хангах;

3. Хилийн олон улсын чанартай боомтод түргэвчилсэн шинжилгээний аргуудыг нэвтрүүлэх, ариутгал халдваргүйтэлд шаардагдах тоног төхөөрөмжөөр яаралтай хангах;

4. “Эбола” вирус халдварыг илрүүлэх лабораторийн оношлогооны бэлэн байдлыг хангах асуудлыг ДЭМБ-тай хамтран шийдвэрлэх;

5. Хилийн чанадад үүрэг гүйцэтгэж байгаа зэвсэгт хүчний энхийг сахиулагч нарын эрүүл мэнд, амь насыг хамгаалах, тархаж буй халдварыг тандах, тархан дэлгэрэх аюулыг нь таслан зогсоох, хээрийн хоёрдугаар шатны эмнэлэг дэлгэн ажиллахад бэлэн байдлыг хангах;

6. “Эбола” вирус халдвар тархаж буй бүс нутаг, улс орны иргэдэд Монгол улсад хувийн болон аялал жуулчлалын чиглэлээр зорчих виз олголтыг чангатгах.

Хоёр.ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргад:

“Эбола” вирус болон бусад шинээр бүртгэгдэж байгаа халдварын тандалт судалгааг өргөжүүлэх, халдварыг эрт илрүүлэх, тархалтаас сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахад хяналт тавьж ажиллах.